

1 Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA) нь буцалтгүй тусламжийн хэлбэрээр, зах зээлийн эдийн засагт шилжих явц дундаа байгаа Азийн орнуудын хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлж байна.

ICCLC нь, Иргэний болон худалдааны хуулийн салбарт дэмжлэг үзүүлэх төслийг гүйцэтгэхээр JICA-тай төсөл гүйцэтгэх гэрээ байгуулсан ба, ICCLC-гийн удирдах албаны хүмүүс, Хууль зүйн зам болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж уг төслийг гүйцэтгэж байна. Мөн, уг төсөлд хамрагдаж буй орнуудын хууль, шүүхийн холбогдох байгууллагууд болон Японд сургалтанд оролцохоор хүрэлцэн ирсэн хүмүүстэй харилцаагаа гүнзгийрүүлж, цаашид энэхүү найрсаг харилцаагаа хадгалаж явах болно.

●● Вьетнам улсын хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл

Японоос хэрэгжүүлсэн хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх анхны төсөл нь 1996 онд эхэлсэн Вьетнам улсад зориулсан төсөл юм. Үүнээс хойш 20 гаруй жилийн турш дэмжлэг үзүүлэх төсөл үргэлжилж байна. “2020 он хүртэлх зорилттой хууль, шүүхийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх төсөл” нь 2020 оны 12-р сарын эцсээр дуусгавар болж, 2021 оны 1-р сараас 2025 оны 12-р сар хүртэлх төлөвлөгөөтэйгөөр “Хуулийн тогтолцоог хөгжүүлэх, хуулийн хэрэгжүүлэлтийн чанар, бүтээмжийг дээшлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

●● Камбодж улсын хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл

1999 оноос “Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж ирсэн ба Камбодж улсын Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн эх боловсруулахад ч Японоос хамтран ажилласан. “Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлсний дараа 2017 оны 4-р сараас 2022 оны 3-р сар хүртэлх төлөвлөгөөтэйгөөр “Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжүүлэлтийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

●● Лаос улсын хуулийн салбарын хүний нөөцийн сургалт, хөгжлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл

2003 оноос хойш “Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна. “Хуулийн салбарын хүний нөөцийн сургалт, хөгжлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл” зэргийг хэрэгжүүлж, 2018 оны 7-р сараас 2023 оны 7-р сар хүртэлх төлөвлөгөөтэйгөөр “Хуулийг дээдлэх ёсыг хөгжүүлэх, бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

●● Индонези улсын хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл

2007 оноос “Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл” эхэлсэн. Одоо, 2015 оны 12-р сараас 2021 оны 9-р сар хүртэлх төлөвлөгөөтэйгөөр “Бизнесийн орчныг сайжруулахад чиглэсэн оюуны өмчийн эрхийг хамгаалах, хууль эрх зүйн тогтвортой байдлыг дээшлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

●● Мьянмар улсын хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл

2013 оноос “Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж ирсэн. 2018 оны 5-р сард анхны “Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл” дуусгавар болж, одоо 2023 оны 5-р сар хүртэлх төлөвлөгөөтэйгөөр “Хууль, шүүхийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

●● Улс тус бүрээр зохион байгуулдаг Япон дахь сургалт

Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сургалтын хамрах хүрээ нь, дээрх орнуудаас гадна Бангладеш, Шри-Ланка, Узбекистан зэрэг орнуудыг ч хамран, хүрээ нь өргөжин тэлж байгаа бөгөөд манай байгууллага JICA болон Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж буй эдгээр сургалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

2 Симпозиум, семинар зохион байгуулж байна.

Япон болон “Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-д хамрагдах орнууд, Азийн бусад орнуудын Иргэний болон худалдааны хуулийн салбарын шүүх, хуулийн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний холбогдох хүмүүс хоорондын харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх зорилго бүхий нээлттэй симпозиум, семинарыг дангаараа болон хамтран зохион байгуулж байна.

●● Япон Хятадын Иргэний болон худалдааны хуулийн семинар

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хэрэгжүүлж буй Хятад улстай Иргэний болон худалдааны хуулийн салбарт харилцан ойлголцоо улам гүнзгийрүүлэх зорилго бүхий семинарыг хоёр оронд ээлжлэн, жил бүр, тасралтгүй зохион байгуулж байна. Хятад улсын хуулийн тогтолцооны шинэчлэлтэй холбогдох тухайн үе бүрийн хандлагын талаар Хятад улсын мэргэжилтнээс мэдээлэл авахын зэрэгцээ, Японы хуулийн тогтолцооны талаар ойлголт авах боломжийг Хятадын талд олгож байна.



Япон Хятадын Иргэний болон худалдааны хуулийн семинар, 2019 оны 11-р сард зохион байгуулав. (Токио)

●● Ази, Номхон далайн бүсийн Иргэний болон худалдааны хэргийн харьцуулсан хуулийн тогтолцооны талаарх судалгааны симпозиум

Ази, Номхон далайн орнууд болон бүс нутгаас эрдэмтэд, бизнесменийг урьж, Иргэний болон худалдааны хуулийн салбарын симпозиумыг зохион байгуулж байна. Ази, Номхон далайн бүсийн Иргэний болон худалдааны хэргийн харьцуулсан хуулийн тогтолцооны талаарх судалгааны нэгдсэн дүгнэлтийн илтгэл тавих боломж олгох симпозиум юм.

●● Олон улсын Иргэний болон худалдааны хуулийн “Каназава семинар”

Ази болон Зүүн Өмнөд Азийн бүсийн Бизнесийн хуультай холбогдох мэдээлэл солилцох, тус бүсийн Бизнесийн болон Эдийн засгийн хуулийн салбарт хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг авах хэрэгцээ шаардлагын талаар, мөн донор хоорондын хамтын ажиллагааны боломж бололцооны талаар санал, мэдээлэл солилцох зорилготойгоор, гадаад дотоодын мэргэжилтнийг урин, семинар зохион байгуулж байна. 2019 онд Каназава хотноо “Зүүн Өмнөд Ази – Бизнесийн өргөжүүлэлтийн өнөөгийн байдалаас” сэдвээр семинар зохион байгуулсан.

●● Симпозиум, семинар

Япон болон тодорхой нэг улсын Иргэний болон худалдааны хуулийн салбарт анхаарал татаж буй сэдвийг сонгон, тухайн улсын мэргэжилтэн гэх мэт холбогдох байгууллага, холбогдох хүмүүсээс дэмжлэг туслалцаа аван, симпозиум, семинар зохион байгуулж байна.

Голлох арга хэмжээнүүдийн нэг нь 2019 оноос эхлүүлсэн Азийн Бизнес Манлайлал Форум (ABLF)-тай хамтран зохион байгуулж буй арга хэмжээ юм. ABLF нь 2019 онд байгуулагдсан ба манай байгууллага ч ABLF-ийг байгуулалсан байгууллагуудынх нь нэг юм. Тус форум нь Ази ба Япон, төр ба хувийн хэвшил, мөн үе үеийнхнийг тус тус холбох 3 гүүр болж, Бизнесийн хуулиас авахуулаад хүний эрх хүртэл Азийн хуулийн талаар өргөн хүрээний мэдлэгийг хуваалцан, олон өнцөгт мэтгэлцээн хийх талбар/форумыг санал болгохыг зорилгоо болгож байна. 2020 онд “Ази дахь бизнес ба хууль” гэсэн сэдвэтийн симпозиум гэх мэт 3 симпозиум зохион байгуулсан.

Мөн, тодорхой нэг улстай холбоотой арга хэмжээний тухайд, 2019 онд Монголоос мэргэжилтэн урьж, “Монгол дахь арилжааны бүртгэлийн системийн талаар” уулзалт лекц зохион байгуулсан.

3 Судалгаа

Азийн орнуудын Иргэний болон худалдааны хуулийн салбарын тодорхой нэг сэдэвтэй холбогдох судалгаа хийх, “Бизнес ба хүний эрх”-ийн салбарын холбогдох материалыг цуглуулж, олон нийтэд нээлттэй дэлгэж ажлыг хийж байна.

●● Ази, Номхон далайн бүсийн Иргэний болон худалдааны хэргийн харьцуулсан хуулийн тогтолцооны талаарх судалгаа

Кансай бүсийн эрдэмтэд, бизнесмен төвтэй судалгааны багийг бүрдүүдүүлэн, өнөөг хүртэлх Ази, Номхон далайн орнуудын Дампуурлын тухай хуулийн тогтолцоо, Барьцааны тухай хууль, ADR, Оюуны өмчийн эрх, Олон улсын компаний тухай хууль, Хувьцаа эзэмшигчид шүүхэд нэхэмжлэл гаргах, Аудитын тогтолцоо, Компаний талаарх мэдээлэл олгох тогтолцоо гэсэн сэдвүүдээр судалгаа хийлгэж байна.

2018 оноос, 3 жилийн төлөвлөгөөтэйгөөр Вьетнам, Индонези, Тайланд, Малайз улсуудыг хамарсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээ, Хөрөнгийн систем, EXIT зэрэг Компаний эрх зүйн практик судалгааг хийж байна.

Өнөөг хүртэлх судалгааны үр дүнг тусгасан хэвлэмэл материал

1. Ази, Номхон далайн орнуудын Дампуурлын тухай хуулийн тогтолцоо
2. Ази, Номхон далайн орнуудын Компаний дампуурал болон барьцааны тухай хууль
3. Ази, Номхон далайн орнуудын ADR-ын өнөөгийн байдал болон цаашдын төлөв хандлага
4. Азийн орнуудын Оюуны өмчийн эрхийн хэрэгжүүлэлт (enforcement)
5. Азийн орнуудын Олон улсыг дамнанас M&A-ийн цаашдын төлөв хандлага
6. Азийн бүсийн Хувьцаа эзэмшигчид шүүхэд нэхэмжлэл гаргах тогтолцооны өнөөгийн бодит байдал болон хувьцаа эзэмшигчдийг хамгаалах
7. Хөгжин дэвшиж буй Азийн бүсийн Аудитын тогтолцооны өнөөгийн бодит байдал болон тулгарч буй асуудал
8. Азийн бүсийн Компаний талаарх мэдээлэл олгох тогтолцооны өнөөгийн бодит байдал болон тулгарч буй асуудал
9. Зүүн өмнөд азийн 4 орны Компаний засаглал

●● Япон Солонгосын хамтарсан судалгаа

1999 оноос эхлэн Солонгосын дээд шүүх болон Японы Хууль зүйн яам, Шүүхийн байгууллагаас тус бүр 5 хүний оролцоотойгоор, Иргэний хэргийн удирдлагын тогтолцооны талаар судалгаа хийж байна. Сүүлд нэг долоо хоног, Токиод нэг долоо хоногийн хугацаатайгаар, хоёр орны мэргэжилтэн нарын лекцийг сонсохоос гадна, практик үйл ажиллагааны талаар судалгаа хийж байна.

●● Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмууд

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс батлагдсан “Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмууд” нь бизнес ба хүний эрхийн чиглэлд бүх улс орон болон компаниас өнөөдөр шаардагдаж буй дэлхийн хэмжээний практик жишгийн стандарт болж олон улсын нийгэмд нэвтэрч эхэлж байна. Тус байгууллага нь Азийн орнуудад бизнесийн хүрээгээ тэлсэн компаниудыг оруулан, өргөн хүрээнд ухуулан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр, Компаний харуцлагын талаарх хэсгийн тухайд, НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газар (OHCHR)-аас гаргасан “Тайлбар гарын авлага”-ын орчуулсан хувилбарыг байгууллагынхаа цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулсны зэрэгцээ, “Хүний эрхийг дээдлэхтэй холбогдох компаний харуцлага, тайлбар гарын авлага”-ыг боловруулж, үүнийг мөн олон нийтэд нээлттэй байршуулсан.

●● Хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдох хамтарсан судалгаа

Тус байгууллага нь Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж буй Азийн орнуудыг судалгааны объект болгосон хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдох хамтарсан судалгаанд оролцож байна. 2019 онд Монгол, Мьянмар, Зүүн Тиморыг судалгааны объект болгосон хамтарсан судалгаа хийгдсэн.

Олон нийттэй харилцах харилцаа, нийтэд нээлттэй материал

Тус байгууллагын цахим хуудас (<https://www.icclc.or.jp>)-нд дараах мэдээллүүд болон бусад олон мэдээллийг олон нийтэд нээлттэй дэлгэсэн байгаа тул, орж харна уу. Үүнд:

- Байгууллагын сэтгүүл “ICCLC”: Удирдах зөвлөлийн хурал болон Зөвлөхүүдийн хурлын агуулга, үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүгийн төсөв
- Үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан гэх мэт тус байгууллагын үйл ажиллагаа болон хөрөнгө санхүүгийн байдлын талаар
- ICCLC NEWS: Мэдээллийн сонин хэлбэрээр симпозиум болон семинар зэрэг бүтээгдэхүүн
- Байгууллагын үйл ажиллагаа, санхүүтэй холбогдох материал
- Байгууллагын удирдах албаны бичсэн нийтлэл зэрэг

Гишүүнээр элсэхийг урьж байна.

■ ICCLC-гийн санхүүгийн үндэс суурь

Үндсэн хөрөнгө	
Үүсгэн байгуулагч 25 компаниас хүлээн авсан хандив	50 сая иен
Үйл ажиллагааны капитал	73.53 сая иен
Гишүүн хуулийн этгээд гишүүнчлэлийн жилийн хураамж	20.9 сая иен
Гэрээгээр гүйцэтгэх ажлын орлого	52.63 сая иен

(Санхүүгийн 2019 он)

■ Гишүүн хуулийн этгээд гишүүнчлэлийн жилийн хураамж

Гишүүнчлэлийн жилийн хураамж нь нэгжийн системтэй ба нэг нэгж нь 0.2 сая иен. Нэг компани нэгээс дээш нэгж гишүүнчлэлтэйгээр элсэнэ. Гишүүнээр элсэхтэй холбогдон асууж лавлах зүйлийн талаар, тус байгууллагын хэрэг эрхлэх газар руу холбоо барина уу.

■ Олон нийтийн эрх ашгийн төлөө корпораци

Тус байгууллага нь, 2013 оны 3-р сарын 18-ны өдөр Япон улсын Ерөнхий сайдаас “Олон нийтийн эрх ашгийн төлөө корпораци” -аар магадлан итгэмжлэгдсэн ба, мөн оны 4-р сарын 1-ний өдөр “Олон нийтийн эрх ашгийн төлөө корпораци” болж өөрчлөгдөх бүртгэлийг хийлгэсэн болно.



Тэргүүн
Мияхара Кэнжи

Сүмитомо Корпорацийн Тусгай Зөвлөх


Миний бие 2003 оны 5-р сард тус байгууллагын Тэргүүнээр томилогдон ажиллаж байна. Япон ба Азийн бусад орнууд хоорондын харилцаа нь бүхий л талаар улам нягтаршихын зэрэгцээ харилцан хараат байдал нь улам нэмэгдэж байна. Тус байгууллага нь Хууль зүйн яам, JICA, JETRO болон холбогдох бусад байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж, Азийн орнуудын хуулийн тогтолцоог хөгжүүлэх, маргааныг шийдвэрлэх аргыг тогтворжуулах, хуулийн мэргэжилтэй хүний нөөцийн сургалт, хөгжил зэргийг дэмжих төсөлд хувийн хэвшлийн байр сууринаас цаашид ч идэвхтэй оролцон, хамтран ажиллана гэж бодож байна. Холбогдох хүмүүс та бүхэн бидний үйл ажиллагааны талаар илүү сайн ойлгож, бидэнтэй хамтарч ажиллахыг хүсье.



Ерөнхийлөгч
Ооно Коотароо

Хуульч
Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын Ерөнхий прокурор асан

Миний бие 2017 оны 6-р сард тус байгууллагын Ерөнхийлөгчөөр томилогдон ажиллаж байна. Глобалчлал улам өргөжиж буй дэлхийд хүн, юм, мэдээллийн солилцоо хурдацтай болж, цар хүрээ нь өргөжин тэлж байна. Энэхүү хөдөлгөөн нь хэмжээлж баршгүй элбэг дэлбэг байдлыг бий болгож байгаа хэдий ч, нөгөөтэйгөөр, бүс нутаг хоорондын баян хоосны ялгаа нэмэгдэх, дэлхийн байгаль орчин муудах зэрэг сөрөг тал нь ч яригдаж байна. Азийн орнууд харилцан ашигтай, тэнцвэртэйгээр хөгжихийн тулд, нийтлэг хууль эрх зүйн зарчим, нийтлэг дүрмийнхээ талаар харилцан магадлангаа, маргаан үүсэхээс сэргийлж, маргааныг шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх нь маш чухал юм. Тус байгууллага нь үүний үндсэн нөхцөл болгон, мэдээллийн солилцоо, хуулийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийн сургалт, хөгжил зэрэгт хувь нэмэр оруулахуйц үйл ажиллагаа явуулахыг зорилгоо болгож байна. Олон хүмүүс бидний үйл ажиллагааг дэмжиж, бидэнтэй хамтарч ажиллахыг хүсье.



Токио метрогийн Гинза шугам, Нанбоку шугам (Тамэ-икэ санно буудал),
9-р гарц (Тамэ-икэ уулзвар)-наас явганаар 3 минут

ICCLC

Олон нийтийн эрх ашгийн төлөө корпораци Олон улсын Иргэний болон худалдааны хуулийн байгууллага

Япон улс, 107-0052 Токио, Минато-кү, Акасака 1-3-5,
Акасака Хабитасион билдинг

TEL: 03-3505-0525 FAX: 03-3505-0833

Ерөнхий нарийн бичгийн дарга Аоки Хиромаса
Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч: Тогами Коо-ичи

E-mail: icclc-sa@js5.so-net.ne.jp

Цахим хуудас: “<https://www.icclc.or.jp>”

